



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/200

Ховд

Ховд аймгийн 2019 оны нэгдүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны халалт, татлагын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Батлан хамгаалах тухай хууль"-ийн 4 дүгээр бүлгийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны мн/213 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2019 оны ..дугаар н/... дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татах, халах, цэргийн албыг гэрээгээр хаах нэгдүгээр цэргийн бэлтгэл үүрэгтэнг элсүүлэх ажлыг 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрөөс 5 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.

2. Аймгийн хэмжээнд цэргийн жинхэнэ албаны халалт, татлагыг удирдан зохион байгуулж ажиллах "Цэрэг татлагын товчоо"-г дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Дарга:	Д.Энхболд	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч дарга:	Б.Ганхуяг	-Цэргийн штабын дарга, дэд хурандаа
Гишүүд:	Н.Ганзориг	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Т.Баяртогтох	-Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал

Б.Батзаяа	-Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн Хурандаа
Б.Мөнгөнцоож	Орон нутгийн хамгаалалт сургалтын офицер, хошууч
Д. Батжаргал	-Жолооч
Нарийн бичгийн дарга: Б.Батмөнх	-Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, дэд хурандаа

3. Сумдын цэрэг татлагад орох хуваарийг 1 дүгээр, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг явуулах бүрэлдэхүүнийг 2 дугаар, цэрэг татлагын зардлын товчоог 3 дугаар, цэрэг татлаганд орох залуучуудын нэрсийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

4. Цэрэг татлагын нэгдсэн үзлэгийг 2019 оны 04 дүгээр сарын 28-наас 30-ны өдрүүдэд, Жаргалант сумын төвд зохион байгуулж явуулах бэлтгэл ажлыг хангуулахыг Жаргалант сумын Засаг дарга /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

5. Цэргийн насны залуучуудад эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг чанартай явуулж, шалгаруулан тэнцүүлэх, эрүүл мэндээр тэнцээгүй залуучуудыг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал /Т.Баяртогтох/-д үүрэг болгосугай.

6. Цэрэг татлагын байрыг зааврын дагуу бэлтгэн бэлэн болгох, цэргийн насны 2 дугаар зэргийн үүрэгтнүүдэд зарлан дуудах хуудас хүргэж, цэрэг татлагын комиссын үзлэгт бүрэн оруулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


7. Хугацаат цэргийн албанд татагдсан болон гэрээгээр цэргийн жинхэнэ алба хаах хүсэлт гаргасан иргэдийг эрүүл мэндийн албан журмын дагуу даатгалд заавал даатгуулж, нийгмийн даатгалын байгууллагаар баталгаажуулсан эрүүл мэндийн дэвтрийг, Эрүүл мэндийн даатгалын хуулийн 9.1.2-т заасны дагуу цусны дэлгэрэнгүй шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ, биохимийн шинжилгээ /элэг, бөөрний үйл ажиллагаа, глюкоз/, БЗДХ, элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээ /уушигны флюор зураг/, зүрхний бичлэг, хэвлийн чанд авиан оношилгоо, шинжилгээний хамт цэрэг татлагын төв байранд авч ирж хүлээлгэж өгөхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Цэрэг татлагын комисс сумдад ажиллах үеэр Батлан хамгаалахын сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн мн/56 дугаар тушаал, н/26 дугаар "Орон нутгийн төлөвлөгөө боловсруулах заавар", Аймгийн Засаг даргын 2019 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/111 дүгээр Орон нутгийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг томилох захирамжийн дагуу шаардлагатай тодотгол, томилгоог хийж "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө" хиих бэлтгэл ажил хангаж ажиллахыг Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер хошууч /Б.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай.

9. Цэрэг халах татах үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг зохих журмын дагуу 7 221 279 төгрөг / Долоон сая хоёр зуун хорин нэгэн мянга хоёр зуун далан есөн /-ийг тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй

10. Цэрэг татлагад шаардлагатай иргэд, албан тушаалтан, машин техникийг дайчлан ажиллуулж, цэрэг татлагын ажлыг 2019 оны 5 дугаар сарын 12-ны дотор багтаан зохион байгуулан, дүнг илтгэхийг Цэрэг татлагын товчооны дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

